Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Элст гол элсний ордын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2024 он хур тунадасны нөлөөгөөр газрын үе давхаргуудад нэвчин бохирдлыг үүсгэнэ.

- Цас борооны усаар хог хаягдал зөөгдөн тархаж хөрс орчныг бохирдуулах
- Ачилт, буулгалт, тээвэрлэлт зэрэг шат дамжлагуудад болон элэгдэж талхлагдсан газраас салхи шуурганы үед үүсэх тоос шороо, утаа тортог эргэн хөрс усан гадаргад бууж тэдгээрийн бүтэц шинж чанарт нөлөөлөх
- Хүчтэй аадар борооны үерийн улмаас бохир усны цооногоос ус алдагдан хөрсний нэвчилтээр дамжин гадаргын усны бохирдол ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх
- Газрын доорх усыг бохирдуулах, гадаргын усыг бохирдох, хог шороогоор дүүрэх, горим нь өөрчлөгдөх, эрэг нь угаагдах, хөрсний угаагдал, элэгдэх, намагших, талбайн ойролцоох барилга байгууламж сууж, эвдрэх зэрэг ус шүүрүүлэлтээс үүсэх нөлөөлөл

5. Төслөөс хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслөөс машин механизм, техник хэрэгслээс шатахуун асгарах, шатахууны түр агуулахад нефтийн бүтээгдэхүүн буулгах, юүлэх үед асгах болон резервуарын гэмтлийн улмаас шатахуун алдах, барилга, байгууламжийн ил задгай хог хаягдал зэргээс хөрс ургамал бохирдож болзошгүй. Мөн машин техникийн тосны хаягдал үүсч хөрс, ургамлыг бохирдуулж болзошгүй юм.

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчид эвдрэл, бохирдлын дараах түгээмэл хэлбэр, өөрчлөлтүүд үүснэ. Үүнд:

- Хөрсний шимт бодисын нөөц хомсдох;
- Хөрсний гадаргын ургамал бүрхэц сийрэгжсэнээр хөрс эвдрэх үйл явц түргэсэх;

Хөрсний хими, физик, геохими, биохимийн хөдлөл зүйн горим өөрчлөгдөх;

- Механик үйлчлэлээр хөрс (машин дугуй, хүний хөл) талхлагдаж сийрэгжих, нимгэрэх;
- Хог ургамалд баригдах, доройтох, цөлжих;
- Хөрс хуурайшиж, бүтэц нь алдагдах;
- Ахуйн хогоор бохирдох;
- Ухсан газарт ландшафтын эвдрэл үүсч, хөрсний генетик үе давхаргууд холилдон морфологи тогтоц бүрмөсөн алдагдах;
- Хөрсний үе давхаргыг хуулснаар борооны усаар дамжин гүний ус бохирдох;
- Хөрс салхинд хийсч элэгдэж эвдрэх үйл явц нь ихсэн тоосжилт нэмэгдэх зэрэг болно.

6. Төслөөс ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Улаанбаатар хотын ургамлын аймгийг бүлгүүдээр авч үзвэл: 70 овгийн, 256 төрлийн, 587 зүйлийн ургамал ургадаг. Тэдгээрээс эхний 10 том овогт өөрөөр хэлбэл 17-гоос дээш зүйлтэй овогт гол гэсэртэн, Биелэгтэн, сарнайтан, буурцагтан, холтсон цэцэгтэн, баширтан, сонгинотон,

байцаатан, өлөнтөн зэрэг овгууд орох бөгөөд эдгээр нь бүх ургамлын 61%-ийг эзэлж байна. Томоохон төрлүүдийн тоонд шарилж, сонгино, гичгэнэ, дэгд, ортууз, тарна. хунчир, шимтэглэй зэрэг орох бөгөөд нийтдээ 108 зүйл буюу 43.7%-ийг эзэлж байна.

Төслийн талбайн гадна ерөнхий бүрхэцийг тодорхойлоход ургамлан нөмрөг нь бүхэлдээ барилга байгууламж, авто машины холхилт, уурхайн олборлолтын нөлөөнд ихээхэн хэмжээгээр доройтсон тул үржил шимээ алдсан байдалтай байна.

7. Төслөөс амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Төслийн талбай дах амьтны аймагт үзүүлэх нөлөөллийн хувьд уурхай нь ашиглалтын хилээр хамгаалалтыг татсан зэрэг байдлаар үзүүлэх нөлөлөл бага байна. Харин төслийн талбайн ойр орчимд нь уурхайн үндсэн үйл ажиллагаанаас улбаатай агаарт тоосжилт үүсэх, дуу чимээний нөлөөллөөр амьтны аймагт дам байдлаар нөлөөлөл үзүүлж болзошгүй байна.

8. Төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл

Ил уурхайн олборлолтын ажил нь тоос болон дуу чимээний нөлөөг ойролцоо нутаглах иргэдэд үзүүлэх болно.

- Оршин суугчид нөлөөллийн бүсийн гадна талд байрлах учир газар ашиглалтын эрх зөрчигдөхгүй.
- Төсөл хэрэгжсэнээр нутгийн иргэд тодорхой хэмжээнд ажлын байраар хангагдана.
- Хамгийн ойр орших суурин газар нөлөөллийн бүсийн гадна байгаа тул сөрөг нөлөөлөлдөртөхгүй.
- Нутгийн иргэд жонш олборлолтын ажилд оролцох бололцоогоор хангагдах;
- Санхүүгийн орлого нэмэгдэх;
- Дэд бүтэц хөгжих;
- Ажилтай холбогдсон сургалтад хамрагдах;

Нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

Налайх дүүргийн нутагт байрлах Элст гол элсний ордыг ашиглах төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүнгүүдийг нэгтгэх нь байгаль орчинд нөлөөлөх гол нөлөөллүүдийг тодорхойлох, төслийн үйл ажиллагааны явцад өртөгдөх байгаль орчны болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсүүд, түүн дэх нөлөөллийн цар хүрээг тогтооход чиглэгддэг.

Хүснэгт №13 Байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
	Нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
1. Байгаль орчин					
Газрын гадарга, хэвлий	0	-2	-1	-2	0
Газрын гадарга ба газар доорх ус	0	-2	-2	0	0
Агаарын чанар	0	-2	-4	-1	0
Хөрс	0	-1	-2	-2	0
Ургамал	0	-4	-2	-1	0

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Элст гол элсний ордын
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2024 он

Амьтан	0	-3	-1	-1	0
Нийт нөлөөллийн тоо	0	14	12	7	0
Эзлэх хувь	0	42 %	36 %	22 %	0
2. Нийгэм эдийн засгийн орчин					
Нутгийн оршин суугчид	0	-1	+3	0	0
Түүх соёлын дурсгал	0	0	0	0	0
Нийт нөлөөллийн тоо	0	1	3	0	0
Эзлэх хувь		25 %	75 %	0	0
Ерөнхий дүгнэлт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нийт 44 хувь нь бага, 35 % нь дунд зэрэг, 21 хувь нь их сөрөг нөлөөтэй байна. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 25 хувь нь бага /сөрөг/, 75 хувь нь дунд зэрэг эерэг нөлөөтэй байна. Дээрх бүгдээс үзэхэд тус төсөл хэрэгжихэд байгаль орчинд болон нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл ДУНД зэрэг сөрөг нөлөөтэй байна.				

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

2024 онд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой БОННУ-д тусгагдсан сөрөг нөлөөллийг уурхайн олборлолтын үед байгаль орчинд учирч болох нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, үүсэх эрсдлийг бууруулах үндсэн зорилгыг тавин үйл ажиллагаагаа явуулсан.

Нөхөн сэргээлт, ногоон байгууламж:

Уурхайн нөлөөллийн бүсэд нэг экосистемтэй байлгах үүднээс “Элст гол” элсний ордын тусгай зөвшөөрөлтэй талбайд байрлах ногоон байгууламжид 2024 онд хөрс сайжруулан бордон, олон наст ургамлын үр цацсан. Ингэхдээ “Монгол хөрс дөрвөн улирлын хүлэмж” ХХК-иас олон наст зүлэгний үрнээс 5 килограммыг худалдан авч, түүнийг тарих ажлыг гүйцэтгэсэн. Түүнчлэн өмнө нь тарьсан байсан моднуудыг услах, арчлах ажлуудыг гүйцэтгэсэн.



Зураг №4. Талбайд тарьсан моднуудын усалгаа

Биологийн нөхөн сэргээлт: Уурхайн хөрсний овоолгод үржил шимт хөрсний овоолго орно. Элст голын элсний ордыг ашиглах явцад жилд хамгийн ихдээ 14.5 мян.м³ хөрс хуулалт хийгдэх бөгөөд үүний улмаас уурхайн орчны экологид тодорхой хэмжээний сөрөг болон эерэг нөлөөлөл бий болохоор байна.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлаар “Монгол хөрс дөрвөн улирлын хүлэмж” ХХК-иас олон наст зүлэгний үрнээс 5 килограммыг худалдан авч ургамалжуулах ажлыг уурхайн ажилчид

өөрсдөө гүйцэтгэсэн. Мөн гадаад овоолго руу очсон дахин ашиглагдахгүй зам зэргийг нөхөн сэргээсэн.



Зураг №5. Талбайд тарьсан олон наст зүлэгний үр



Зураг №6. Талбайд зүлэгний үр цацах үе



Зураг №7. Талбайд зүлэгний үр цацах үе

Техникийн нөхөн сэргээлт: Нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн ашиглалтын 3 дэх жилд уурхайн гадаад овоолгод техникийн нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэхээр төсөлд тусгасан бөгөөд 1.6 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн.

Техникийн нөхөн сэргээлтэнд ажиллах бульдозерын ажилд гадаад овоолгын хажууг 18 градус болгон налуулах, уурхайн хажууг мал амьтан явах боломжтой болгож хэвгийжүүлж хэлбэршүүлэх, техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайг шимт хөрсөөр 0.15-0.2м зузаантайгаар хучих зэрэг ажлууд багтана. Хөрсний гадаад овоолго, хөрсний дотоод овоолго, ил уурхайн ханыг налуулах ажлууд нь ашиглалтын 3 дэхь жилээс тодорхой үе шаттайгаар хийхээр ТЭЗҮ, БОННУ тусгаж өгсөн байна.



Зураг №8. Талбайд хойд хэсэгт хийгдэж байгаа техникийн нөхөн сэргээлт

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт: Техник технологи галын аюулгүй байдлын бүрэн хангуулах, болзошгүй осол эрсдлийн үед ажилчдыг болон шаардлагатай техник тоног төхөөрөмжийг бэлэн байхад бэлтгэсэн бөгөөд бүх ажилдчыг Налайх дүүргийн гал унтраах, аврах 28-р ангийн хамт олонтой хамран гал түймэр унтраах мэргэжлийн сургалтанд хамруулсан. Түүнчлэн “Төгс баян хүрээ” ХХК-ийн тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулан, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх анхан шатны тусламжийн эмийн санг ажлын байранд бий болгосон.



Зураг №9. Гал унтраах сургалт орж буй байдал



Зураг №10. Галын практик сургалт



Зураг №11. Галын практик сургалт



Зураг №12. Уурхайн гал унтраах хэрэгслүүд

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт: Тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө болон ажил хийгдээгүй болно.

Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт: Уурхай эхэлж байгаатай холбоотой хог хаягдлын менежментийг тусгаж хог ангилан ялгах стандарт шаардлааг хангасан цэг бий болгосон, шаардлага хангасан битүүмж сайн хогийн савнуудыг ажилчдын байр газарт байрлуулсан. Ахуйн хуурай хог хаягдлыг цэвэрлэн ангилан ялгах хогийн цэгт битүүмжлэл сайтай хурааж, 1 машин буюу 30 тн-ы хэмжээнд хүрэхээр орон нутгийн зөвшөөрөгдсөн нэгдсэн хогийн цэгт хаяж байгаа. Хог хаягдлын бохирдол үүсгэхээс сэргийлж ажилчдад сургалт орсон, байнгын хяналтыг тавьж ажиллаж байгаа. Налайх дүүргийн хот тохижилтын газартай гэрээ байгуулан хог хаягдлаа ачуулж байгаа. Түүнчлэн шатах тослох материалыг нийлүүлэх гэрээг Алтан оршихуй групптэй байгуулан ажиллаж байна.



Зураг №13. Хог хаягдлын цэг, хашаалсан байдал

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт: Тэрбум мод төслийн хүрээнд Налайх Дүүргийн Засаг Даргын Тамгын газартай албан бичгийн хүрээнд харилцан Налайх дүүргийн засаг даргатай уулзан олон жил цэцэглэх боломжтой голт бор модны үрсэлгээг 60 ширхэгийг Монгол хөрс дөрвөн улирлын хүлэмж ХХК-иас худалдан авч хүлээлгэн өгөв. Энэхүү модлог ургамал нь Налайх дүүргийн Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд таригдах юм.



Зураг №14. Голт бор модны суулгац




Зураг №15. Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд голт бор модны суулгацуудыг хүлээлгэн өгөв.



Зураг №16. Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнгийн харагдах байдал

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр: Тус хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг хариуцан хийсэн. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг агаарын бохирдол тоосны шинжилгээг 1 удаа төсөл хэрэгжих талбайн зонхилох салхины дээд доод талд хяналтын 1 цэг сонгон Байгаль орчны хэмжилзүйн төв лабораториар хийлгэсэн. Түүнчлэн талбайгаас хөрсний 2 дээжийг E685300, N5296900 болон E685250, N529700 солбицлуудаас 2 удаагийн давтамжтайгаар Хөрс – 1, 2, 3, 4 нэртэй дээж авч хөрсний шинжилгээнд, шүүрлийн уснаас E685400, N5296900 солбицлоос 2 удаа усны дээжийг авч Шүүрлийн ус – 1, 2 нэртэйгээр Инженер геодези ХХК-ийн лабораторид шинжилгээнд хамруулсан. Шинжилгээний хариунуудыг тайланд хавсаргасан.



Зураг №17. Усны дээж



Зураг №18. Хөрсний дээж – 3, 4



Зураг №19. Агаарын дээж авч буй байдал

БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах

Төсөл хэрэгжүүлэгч “БММЖ” ХХК жил бүр БОМТ -ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэн ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлэн ажиллаж байгаа.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлсэн ажил	2024 онд БОМТБ –нд зарцуулсан зардал /төгрөг/	Биелэлт
1	Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар, улирлаар оновчтой тогтоох	ҮАЗ	Тээвэрлэлтийн зам, уурхай, кемп орчмыг тоосжилтоос сэргийлж тогтмол усаар шүршиж, усалж байсан. Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа хийсэн.
2	Ажлын байрны агаарын чанарыг сайжруулах, тоосжилтыг бууруулах арга хэмжээ тогтмол авч байх	200.00	
3	Уур амьсгалд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хүлэмжийн хийг ялгаруулж буй эх үүсвэрүүдийн мэдээллийг бүртгэх, тооцоолно.	ҮАЗ	
4	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгаа хийнэ.	ҮАЗ	
5	Салхи ихтэй үед хөрс хуулах, ачиж тээвэрлэх үйлажиллагааг хязгаарлах	ҮАЗ	
6	Дотоод болон гадаад тээврийн замыг салхи ихтэй, хуурайшилттай өдрүүдэд услах, замыг хусаж байх	ҮАЗ	
7	Хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ.	ҮАЗ	Хурдны хязгааралтыг тэмдэг тэмдэглэгээг байршуулсан
8	Овоолго болон барилгын ажлын үед тоосжилт үүсгэж болзошгүй талбайнуудад усалгаа хийнэ	ҮАЗ	Овоолго болон барилгын ажлын үед тоосжилт үүсгэж болзошгүй талбайнуудад усалгааг тогтмол хийсэн

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Элет гол элсний ордын
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2024 он

ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧ, УРГАМЛАН НӨМРӨГ			
9	Авто тээврийн хэрэгслийн сул хөдөлгөөнийг хориглох, тогтсон маршрутаар зорчуулах	ҮАЗ	Авто тээврийн хэрэгслийн сул хөдөлгөөнийг хориглох, тогтсон маршрутаар зорчуулсан
10	Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах	100.00	Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулсан.
11	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдал гэхмэт аюултай хог хаягдлын бүртгэл гаргах	350.00	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдал гэхмэт аюултай хог хаягдлын бүртгэл гарган, шатах тослох материал нийлүүлэх гэрээ байгуулсан
12	Хог хаягдлыг тогтсон нэг цэгт төвлөрүүлж, ангилан ялгах, ариутгах зайлуулах,	693.00	Хог хаягдлыг тогтсон нэг цэгт төвлөрүүлж, ангилан ялгаж, Налайх дүүргийн хот тохижилтийн газартай гэрээ байгуулсан.
Дүн		1343.00	

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Элст гол элсний ордын
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2024 он

ГАДАРГЫН ДООРХ УС			
13	Унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг арвиланхэмнэх, ус хэмнэлтийн менежментийг хэрэгжүүлэх	ҮАЗ	Унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг арвиланхэмнэн, ус хэмнэлтийн менежментийг хэрэгжүүлсэн
14	Жил бүр ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар гаргуулах	1071.00	2024 оны ус ашиглах дүгнэлтийг Туул голын усны сав газраар гаргуулан, хаягдал усны болон усны төлбөрийг төлөж, бохир зайлуулах гэрээг иргэн Болд-Эрдэнэтэй байгуулсан.
Дүн		1071.00	
АМЬТНЫ АЙМАГ			
15	Төслийн талбай орчимд шувууны суудал хийж байрлуулах, нурж эвдэрсэн тохиолдолд засварлах	-	Төслийн талбай орчимд шувууны суудал хийх гэсэн боловч дуу чимээ ихтэй болохоор модонд байрлах шувуу байсангүй.
16	Ажилчдыг хууль бусаар анхийхгүй байхыг анхааруулах, хяналт тавих	ҮАЗ	--*--
НИЙТ		2414.00	



Зураг №20. Замын тэмдэгжүүлэлт

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

№	Хэрэгжүүлсэн ажлын нэр	Хэмжих нэгж	Талбайн хэмжээ	2024 онд зарцуулсан зардал мян.төг
Биологийн нөхөн сэргээлтийн зардал				
1	Хөрс сайжруулах бордсон	га	0.8	400.00
2	Олон наст ургамлын үр цацсан	га	0.9	1000.0
3	Усалгааны зардал	га	1.7	200.00
НИЙТ ЗАРДАЛ				1600.0

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөөний биелэлт

Төслийн MV-017556 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд зайлшгүй нүүлгэн шилжүүлэх шаардлагатай асуудал байхгүй байна.

Түүх, соёлыг өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт

Төсөл хэрэгжих уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно. Уурхайн ажиллах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илрээгүй болно.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11 -д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг. Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	2024 онд БОМТБ –нд зарцуулсан зардал (сая.төг)
Ан амьтныг хамгаалах	Налайх дүүргийн Засаг Даргын Тамгын Газарт 60 ширхэг олон наст цэцэглэдэг мод хандивласан.	1.0
НИЙТ		1.0

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	2024 онд БОМТБ –нд зарцуулсан зардал /мян.төг/
Хээрийн түймэр уурхайн талбай, кэмпрүү орж ирэх, уурхайн хээрийн түймэрт өртөх	Хээрийн түймрээс сэргийлж уурхайн талбайг тойруулан зурвас, далан байгуулсан	Үйл ажиллагааны зардалд
Түлшний агуулах, засварын газар, ажилчдын байр, цахилгаан үүсгүүр бүхий газруудад гал түймэр гарах магадлалтай. Мөн хаврын хуурайшилт ихтэй өдрүүдэд тамхины цог зэргээс хээрийн түймэр гарч болзошгүй	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаах дүрэм, журам боловсруулж мөрдлөг болгон ажилласан	Дотоод журам
	Бүх ажилчдыг гал түймэр унтраах мэргэжлийн сургалтад хамруулсан	350.00

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Элст гол элсний ордын
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2024 он

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	2024 онд БОМТБ –нд зарцуулсан зардал /мян.төг/
	Галын дохиолол, гал унтраах багаж хэрэгслийг шаардлагатай газруудад байрлуулсан	Үйл ажиллагааны зардалд
	Гал түймрээс сэргийлэх талаар анхааруулга, санамжийн хуудас хийж, шаардлагатай газруудад нүдэнд харагдахуйц газруудад байрлуулсан	Үйл ажиллагааны зардалд
Үйлдвэрлэлийн осол, аваар, ажилчид бэртэх, эрүүл мэнд хохирох, амь нас эрсдэх, уурхайн үйл ажиллагаа саатах, тоног төхөөрөмж эвдэрч гэмтэх	Ажилчдыг ээлжинд гарахын өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаанд хамруулах	-
	Мэргэжлийн байгууллага, мэргэжилтний тусламжтайгаар хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулсан	500.00
	Осол аваар гарч хүний эрүүл мэнд хохирсон тохиолдолд яаралтай анхан шатны тусламж үзүүлэх, анхан шатны тусламжийн эмийн сангмашины кабин, ажлын байрт байрлуулсан	100.00
	Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангасан	Үйл ажиллагааны зардалд
Жолооч нарын санамсар болгоомжгүй үйлдлээс машин техникүүд мөргөлдөх, хүн амьтан дайрах, мөргөх зэргээр гэмтээж бэртээх гэх мэт осол аваар гарах	Жолооч нарыг аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулсан Анхааруулга, замын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад байрлуулсан Уурхайн талбай дотод таних тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан	Сөрөг нөлөөллийг бууруулах зардалд тусгасан
НИЙТ		950.00

Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2024 онд БОМТБ –нд зарцуулсан зардал /мян.төг/
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлуулаагүйгээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилан, дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулан, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авсан	Үйл ажиллагааны зардалд
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийж, ажилчдын байр, ШТС зэрэг газарт байрлуулсан	Үйл ажиллагааны зардалд
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан, ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлж байгаа	700.00
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгч байгаа	Үйл ажиллагааны зардалд
НИЙТ		700.00

БОМТБТ-г хэрэгжилтийн нөлөөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч “БММЖ” ХХК жил бүр БОМТ -ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлж байгаа.

Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, байгаль орчны бохирдлоос сэргийлэх, тогтвортой уул уурхайг дэмжих үүрэг хүлээсэн бөгөөд ажилчид, орон нутгийн иргэд болон бусад сонирхогч талуудад төслийн байгаль орчны бодлого үйл ажиллагааг нээлттэй болгох, ажил хэрэгч харилцааг дэмжих үүднээс төслийн БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнан, хэлэлцүүлж байгаа

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршинсуугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов
Хорооны ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагдаж байгаа	10-р сар
БОАЖЯ-ны ХБОБНУГ-г	Тухайн жилийн БОМТ , тайлан	Тайланг хүлээн авсан актыг Хүргүүлж байгаа	12-р сар

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгээр үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна. Байгаль орчны асуудал нь зөвхөн байгаль орчны ажилтан, мэргэжилтэнүүд анхаарал хандуулах биш захирлаас эхлээд тогооч, цэвэрлэгч, жолооч гээд уурхайн бүхий л ажилтнуудын анхаарал хандуулах чухал асуудал юм.

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал, сая.төг
Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Нийгмийн хариуцлагын хүрээнд	тохиролцох
НИЙТ		-

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	2024 онд БОМТБ –нд зарцуулсан зардал /мян.төг/	Баримтлах арга, аргачлал, стандарт,шаардлагууд
Агаарын чанар						
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Уурхайлалт явагдаж буй талбайд	Талбайд хяналтын 1 цэг	1 удаа	НИЙТ 86.0 төг	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
1.2	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн нийт үйл ажиллагаанаас орчинд тоосжилт үүсэх, тархах				
1.3	Дуу шуугиан, чичиргээ:	Машин механизмын ажиллагаа хөдөлгөөнөөр шуугиан үүсэх				
Хөрсний бохирдол						
2.1	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс, ялзмагийн агууламж, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд хяналтын 2 цэгээс авсан.	2 удаа	Нийт 171.600 төг	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга,

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Элст гол элсний ордын
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2024 он

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	2024 онд БОМТБ – нд зарцуулсан зардал /мян.төг/	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Усны хяналт шинжилгээ						
2.1	Усны чанар рН, ууссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий шинжилгээ	Шүүрлийн усыг байгальд асгах	Шүүрлийн уснаас авсан E 685400 N 5296900	2 удаа	Усны шинжилгээ 49,5 х 1 цэг х 2 удаа х 1 жил = 99.00	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 Гадаад орчны уснаассорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт MNS 0900 : 2005 Ундны ус. Эрүүл ахуйншаардлага, түүнд тавих хяналт
ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН					356.600	

**2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАНГИЙН НИЙТ ЗАРДАЛ**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал / төгрөг / 2024 он
1	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,600,000
2	Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	1,000,000
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	700,000
4	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө	950,000
5	Сөрөг нөлөөллийг буруулах арга хэмжээний төлөвлөгөө	2,414,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	356,600
Нийт		7,020,600

ДҮГНЭЛТ

“БММЖ” ХХК-ийн Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Элст гол”-ын элсний орд төслийн нөхөн сэргээлт хийсэн ажлын 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг “БММЖ” ХХК-тай БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тоот БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсрууллаа.

“БММЖ” ХХК нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, цаг тухай бүрт шаардлагатай арга хэмжээнүүдийг авч сөрөг нөлөөллийг бууруулж ажилласан.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Элст гол” элсний ордыг ашиглах төслийн 2021 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө
2. Улаанбаатар хотын налайх дүүргийн “Элст гол” элсний ордын БОННУ тайлан, 2022 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудитын журам, аргачлал /гарын авлага/ УБ 2014 он
4. БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ний өдрийн А-618 тоот “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам.

“БММЖ” ХХК

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 10-р
хороо, Зүүн наран 3, 05 тоот
Утас:976-94119209

**НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ГАЗАРТ**

2024.10.29 № 08/24

таниаг _____ -ны № _____ -т

Хүсэлт гаргах нь

Манай компани нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 5-р хорооны нутагт орших MV-017556 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Элст гол” нэртэй талбайг эзэмшдэг. Элст гол элсний ордын 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг Нийслэлийн Байгаль Орчны газарт хүргүүлд байна.

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлантай танилцаж дүгнэлт гаргаж өгнө үү.

ЗАХИРАЛ



/Л.ДАШИЙХҮҮ/



**АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2013 оны 11 сарын 18 өдөр

Дугаар 429

Улаанбаатар хот

Нөөц бүртгэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2013 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны ХХ-17-06 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Хуралдааны дүгнэлтийн дагуу хүлээн авсан Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Элст гол нэртэй XV-014720 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах элсний нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Геологийн мэдээллийн төв архив (Р.Энхсайхан)-т зөвшөөрсүгэй.

ДАРГА



Г.АЛТАНСҮХ

10 1235

УУЛ УУРХАЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2013 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар ХХ-17-06

Улаанбаатар хотын Налайх дүүргийн
нутагт орших Элст голын элсний ордод
2012-2013 онуудад гүйцэтгэсэн хайгуулын
ажлын үр дүнгийн тайланг хэлэлцсэн тухай

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Элст голын элсний ордод 2012-2013 онуудад гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгээр геологич Б.Золбоо, Г.Гантуяа нарын боловсруулсан тайлан, уг тайлан болон элсний ордын нөөцийн тооцоонд МУ-ын зөвлөх инженер, геологич Т.Ганбаатар, элсний түүхий эдийн чанарт МУ-ын зөвлөх инженер Ч.Оч нарын хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд дараахь ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Элст гол нэртэй 19.29 га талбай бүхий XV-014720 тоот тусгай зөвшөөрлийг АМГ-ын ГУУКХ-ээс 2009 оны 02-р сарын 06-ны өдөр “БММЖ” ХХК-д олгосон байна.

“БММЖ” ХХК нь тусгай зөвшөөрөлтэй 19.29 га талбайд хайгуулын ажил гүйцэтгэж, элсний бодитой (В) нөөцийг тогтоон, хайгуулын ажлын зардалд 13437856.0 төгрөг зарцуулсан байна.

2. Элст голын элсний орд нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших ба Улаанбаатар хотоос зүүн-урагш 55 км-т оршино.

Уул зүйн байрлалаар ордын район нь Хэнтийн уулархаг мужийн баруун-урд хэсэгт харьяалагдах бөгөөд 1944 онд Ю.С.Желубовский, М.А.Анпилов нар Улаанбаатар хот орчмын талбайд 1:200000-ны масштабтай геологийн зураглалын ажил хийжээ. 1941 онд геологич Ф.К.Шипулин Элст голын хөндийн баруун дэнжид эрэл, хайгуулын ажил хийж элсний бодитой болон боломжтой (В+С) нөөцийг 2603.0 мян.м³-ээр тооцжээ.

3. “БММЖ” ХХК нь XV-014720 тоот тусгай зөвшөөрөлтэй Элст гол нэртэй талбайд хайгуулын ажлыг шурф нэвтрэлт, дагалдах сорьцлолтыг хийж лабораторийн шинжилгээг Барилга архитектур корпорацийн Барилгын материалын лаборатори ба МУИС-ийн харьяа Цөмийн судалгааны төвөөр тус тус хийлгэсэн байна.

Элсний хайгуул хийсэн 19.29 га талбайд 1:1000-ны масштабын байр зүйн зураглалыг “Жи Ди Эс Эс” ХХК хийж, хайгуулын бүх малталтуудыг Улсын геодезийн тулгуур сүлжээнд холбуулжээ.

4. Ордын элсний лаборатори-технологийн туршилтын сорьцын үр дүнгээс үзэхэд 1 м³ бетоны найрлага дахь элс, хайрга, цемент, усны харьцаа 1:1:3.7:4.6, конусын суулт 4-6 байхад М100 маркийн бетон, 1:0.9:2.8:4.5, конусын суулт 4-6 байхад М200 маркийн бетон, 1:0.8:2.1:4.4, конусын суулт 4-6 байхад М300 маркийн бетон, 1:0.7:1.7:4.3, конусын суулт 4-6 байхад М400 маркийн бетоны стандартыг хангаж байгааг, хүйтэн тэсвэрлэлт (сульфат тэсвэрлэлт)-ийн итгэлцүүр нь 1.27-1.57 байгаа нь түүгээр үйлдвэрлэсэн бетон нь хүйтэнд тэсвэртэй байхыг тус тус тогтоосон байна.

Дээр дурьдсан үзүүлэлтүүд нь уг ордын элс нь чанарын хувьд МNS-2513-99 стандартын шаардлагыг хангаж байгаа ба түүгээр 100-400 маркийн бетон үйлдвэрлэх

мөн MNS-0392-1998 буюу барилга байгууламжийн ажилд хэрэглэх элсний стандартыг хангаж байгаа нь барилгын өрлөг, зуурмагт, химийн шинжилгээний үр дүнд SiO_2 -ийн агуулга 69.1-71.9% байгаа нь шилний үйлдвэрт хэрэглэх боломжтой гэж дүгнэсэн байна.

Цацраг идэвхижлийн судалгаагаар ордын элсний радийн эквивалент нь 13.5-29.9 Бк/кг, дунджаар 23.2 Бк/кг байгаа нь барилгын материалд түүний зөвшөөрөгдөх хэмжээ 370 Бк/кг-аас 15.9 дахин бага байгаа нь элс олборлоход бүрэн тохирох ба эрүүл ахуйн ямар нэг сөрөг нөлөөлөл байхгүй гэж үзжээ.

5. Нийтдээ ордод бодитой (В) нөөцийн 3 блок ангилсан ба 5.0 м хүртэлх гүнээр тооцоолжээ.

В-1 блокийн хэмжээнд элсний ширхэгийн найрлага нь 2.5 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 7.19%, дундаж бүрэн үлдэгдэл 7.19%, 1.25 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 4.13%, дундаж бүрэн үлдэгдэл 11.32%, 0.63 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 7.76%, дундаж бүрэн үлдэгдэл 19.08%, 0.315 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 29.48%, дундаж бүрэн үлдэгдэл 48.68%, 0.14 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 42.22%, дундаж бүрэн үлдэгдэл 90.90%, <0.14 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 9.10%, дундаж бүрэн үлдэгдэл 100%, элсний ширхэгийн дундаж модуль 1.8, шаварлаг тоосорхог хэсгийн дундаж агуулга 2.9%, элсэнд агуулагдах хайрганы дундаж агуулга 8.3%, элсний асгаасан нягт 1428.2 кг/м^3 байна.

В-2 блокийн хэмжээнд элсний ширхэгийн найрлага нь 2.5 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 8.73%, дундаж бүрэн үлдэгдэл 8.73%, 1.25 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 4.59%, дундаж бүрэн үлдэгдэл 13.33%, 0.63 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 9.33%, дундаж бүрэн үлдэгдэл 22.65%, 0.315 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 22.63%, дундаж бүрэн үлдэгдэл 48.98%, 0.14 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 36.81%, дундаж бүрэн үлдэгдэл 85.81%, <0.14 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 14.19%, дундаж бүрэн үлдэгдэл 100%, элсний ширхэгийн дундаж модуль 1.8, шаварлаг тоосорхог хэсгийн дундаж агуулга 3.8%, элсэнд агуулагдах хайрганы дундаж агуулга 10.0%, элсний асгаасан нягт 1447.6 кг/м^3 байна.

В-3 блокийн хэмжээнд элсний ширхэгийн найрлага нь 2.5 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 7.39%, дундаж бүрэн үлдэгдэл 7.39%, 1.25 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 4.74%, дундаж бүрэн үлдэгдэл 12.13%, 0.63 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 8.85%, дундаж бүрэн үлдэгдэл 20.98%, 0.315 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 24.48%, дундаж бүрэн үлдэгдэл 45.33%, 0.14 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 38.0%, дундаж бүрэн үлдэгдэл 83.47%, <0.14 мм хэмжээтэйгээр дундаж хэсэгчилсэн үлдэгдэл 16.53%, дундаж бүрэн үлдэгдэл 100%, элсний ширхэгийн дундаж модуль 1.8, шаварлаг тоосорхог хэсгийн дундаж агуулга 4.1%, элсэнд агуулагдах хайрганы дундаж агуулга 8.4%, элсний асгаасан нягт 1472.4 кг/м^3 байна.

6. Зохиогчид Элст голын элсний ордын бодитой (В) нөөцийг 762011.3 м^3 -ээр тооцож, урьдчилсан үнэлсэн баялаг (P_1)-ийг 1802831.0 м^3 -ээр үнэлсэн байна. Элсний нөөцийг хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд тооцсон тул цаашид талбайн хэмжээнд нөөц өсгөх боломжгүй, харин гүн рүү нь нөөц өсгөх боломжтой гэжээ.

Орд нь хуулга хөрс багатай, дунджаар 0.6 м-ээс ихгүй бөгөөд хуулга хөрс ашигт малтмалын харьцаа 1:7 байна.

Шинжээч дээрхи нөөцийн тооцоонд хяналтын хэмжилт, тооцоо хийж, ордын элсний нөөцийг тооцоолж, зохиогчийн хувилбараар хүлээж авахыг санал болгосон ба ЭБМЗ-ийн хуралдааны үед Зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар ордын нөөцийг шинжээчийн

санал болгосноор зохиогчийн хувилбараар хүлээн авч, ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэхийг зүйтэй гэж үзсэн байна.

7. Элст гол элсний ордын хайгуулын малталтуудад хөрсний ус илрээгүй. Үйлдвэрийн болон ундны усны хэрэгцээг Налайх дүүргийн гүний худгаас хангахаар төлөвлөсөн байна.

8. Элст голын элсний ордыг олборлох техник-эдийн засгийн урьдчилсан тооцоонд ордыг тээвэрлэлтгүй ашиглалтын системээр ил аргаар олборлохоор тусгасан бөгөөд ашиглалтын нөөц 726.0 мян.м³, жилийн хүчин чадал дунджаар 96.0 мян.м³, нийт орон тоо 11 хүн, нийт хөрөнгө оруулалт 620.0 сая төгрөг, жилийн ашиглалтын зардал 399.8 сая төгрөг, 1 м³ элсний өөрийн өртөг 4165.5 төгрөг болж байна.

1 м³ элсийг карьер дээрээсээ 8000 төгрөгөөр борлуулахад жилд дунджаар 768.0 сая төгрөгийн борлуулалт хийж, 244.9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаар хөрөнгө оруулалтаа 2.5 жилийн хугацаанд нөхөх тооцоо гаргасан байна.

9. Байгаль орчныг нөхөн сэргээх, нөлөөллийг бууруулах, хамгаалах зардалд урьдчилсан байдлаар 11 сая.төг төлөвлөсөн байна.

10. Цаашид байгаль орчны үнэлгээнүүд болон орд газрыг ашиглах ТЭЗҮ-ийг эрх бүхий этгээдээр үндэслэлтэй боловсруулуулах, ус ашиглах дүгнэлтийг холбогдох газраар гаргуулах, байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд онцгой анхаарч ажиллах мөн Монгол улсын хууль тогтоомж, дүрэм журмыг баримталж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

Шинжээчийн дүгнэлт, Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас дараахь зөвлөмжийг гаргав:

1. "Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Элст голын элсний ордод 2012-2013 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайлан" (Ордын нөөц 2013 оны 5 дугаар сарын 01-ний байдлаар) дахь Элст гол нэртэй XV-014720 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах элсний бодитой (В) нөөцийг 762011.3 м³ -ээр зохиогчийн тооцоолсон хувилбараар хүснэгт-1-ийн дагуу хүлээн авах.

2. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан Элст гол нэртэй XV-014720 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарагдах элсний нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Геологийн мэдээллийн төв архив (Р.Энхсайхан)-д зөвшөөрөх.

3. Энэхүү дүгнэлтийн 10-т заасан зүйлийг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг "БММЖ" ХХК-д анхааруулах.

4. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэрийн дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу гаргасан АМГ-ын даргын тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Геологийн мэдээллийн төв архивт хүлээлгэн өгөхийг "БММЖ" ХХК-д даалгах.

5. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших Элст голын элсний ордод 2012-2013 онд гүйцэтгэсэн геологи-хайгуулын ажил, дээжлэлт, тайлан боловсруулалтын ажлын үнэмшил, чанарыг тайлан зохиогч геологич Б.Золбоо, Г.Гантуяа, лабораторийн шинжилгээний үр дүнгүүдийг Барилга архитектур корпорацийн Барилгын материалын лаборатори ба МУИС-ийн харъяа Цөмийн судалгааны төв, 1:1000-ны масштабын топо зураглалын ажлыг “Жи Ди Эс Эс” ХХК тус тус хариуцах, дээрх гүйцэтгэсэн ажлуудын үнэн бодит байдал, чанарыг хянаж гаргасан дүгнэлтийг МУ-ын зөвлөх инженер Т.Ганбаатар болон “БММЖ” ХХК хариуцах.

ТАНИЛЦСАН:

ЭБМЗ-ИЙН ДАРГА,
УУЯ-НЫ СБТГ-ЫН ДАРГА

Ч. ОТГОЧУЛУУ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭБМЗ-ИЙН АШИГТ МАЛТМАЛТАЙ
ХОЛБООТОЙ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭХ
САЛБАР ХУРАЛДААНЫ ДАРГА,
УУЯ-НЫ БХЗГ-ЫН ДАРГА

Б. БАТХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.НАРАНЦЭЦЭГ



ЭБМЗ-ийн 2013 оны 9 дүгээр сарын 24-
ний өдрийн ХХ-17 дугаар хуралдааны ХХ-17-
06 дугаар дүгнэлтийн хавсралт



Элст гол элсний ордын нөөцийн тооцооны хүснэгт

/XV-014720/

№	Нөөцийн зэрэг, блокын дугаар	Блокын талбайн хэмжээ /м ² /	Ашигт малтмалын зузаан / м /	Блокын ашигт малтмалын нөөцийн хэмжээ / м ³ /	Хуулах хөрсний зузаан /м/	Хуулах хөрсний хэмжээ /м ³ /	Ашигт малтмалын нөөцийн хэмжээг хуулах хөрсний хэмжээтэй харьцуулсан харьцаа
1	В-1	59372.3	4.21	249957.4	0.61	36217.1	6.9
2	В-2	60123.6	4.24	254924.1	0.59	35472.9	7.2
3	В-3	60787.2	4.23	257129.9	0.60	36472.3	7.1
Дүн В		180283.1		762,011.3		108162.3	
Дундаж В			4.23		0.6		7.0

Нөөцийн тооцоог хийсэн геологич Б.Золбоо



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2021 оны 05 дугаар сарын 19

№ Т/21-09-05

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших MV-017556 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Элст гол”-ын элсний ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хэлэлцсэн тухай

“БММЖ” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Рояал Рэнж” ХХК боловсруулсан Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Элст гол”-ын элсний ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголд Монгол Улсын зөвлөх инженер Ч.Хэрлэн зөвлөж, Монгол Улсын зөвлөх инженер Г.Рэнцэндорж шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Техник-эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.
2. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах үндсэн баримт бичиг болжээ.
3. Техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол нь “Элст гол”-ын элсний ордын геологийн товч тодорхойлолт, Ил уурхайн олборлолт, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт хаалтын төлөвлөлт, Уурхайн эдийн засаг зэрэг 8 бүлэг, дүгнэлт, хавсралт материал бүхий 96 хуудас тайлбар бичиг, 9 хавсралт зургуудаас бүрдэж байна.
4. “Элст гол” нэртэй MV-017556 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2013 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн ХХ-17-06 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГ-ын даргын 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 429 тоот тушаалаар элсний нөөц нь бодитой В зэргээр 762.0 мян.м³ гэж улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

5. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо ашиглалтын үеийн хаягдал 1.8% (12.6 мян.м³), бохирдлыг 2.8%-аар (18.9 мян.м³) авч тооцсон байна. Ордыг 8 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 109.8 мян.м³ хөрс хуулж, үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцсоноор 690.8 мян.м³ элс олборлохоор төлөвлөжээ. Жилийн хүчин чадал 90.0 мян.м³ хүдэр бөгөөд хөрс хуулалтын итгэлцүүр 0.16 м³/ м³ байна.

6. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын уул геологийн тогтоц, хучаас хөрсний зузаан, физик механик шинж чанар зэргийг харгалзан үзэж ил уурхайг авто тээвэр, дотоод овоолготой ил уурхайн ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

7. Ил уурхайд HYUNDAI 320L маркийн экскаватор 1ш, 25 тн даацтай Howo маркийн автосамосвал 2ш, ZL-50F маркийн утгуурт ачигч зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар тусгажээ.

8. Ордын туршилт судалгаа, түүхий эдийн чанарын шинжилгээг МУИС-ын харъяа Цөмийн судалгааны төв болон Барилга Архитектур Корпорацийн Барилгын Материалын лабораторид хийж гүйцэтгүүлсэн байна. Шинжилгээгээр элсний нягт 2.37 г/см³, тоос шаврын хольц 3.4%, элсэнд агуулагдах хайрга 9.9% зэрэг үр дүнгүүд гарсан байна.

9. Ил уурхайгаас ирэх элс нь бункерээр дамжин чичиргээт тэжээгүүрээр жигд тэжээгдэн чичиргээт шигшүүрт зөөгдөн ирсний дараа +0-3мм, +3мм -ээс дээш гэх ангиудад ангилагдаж байна.+0-3 мм, +3 мм-ээс дээш тус бүрийн гарц 80%, 20% байхаар тооцжээ.

10.Одоогийн байдлаар "Элст гол"-ын уурхай нь цахилгаан хангамжийг ТЭХС-ээс, усан хангамжийг гүнийг худгаас тус тус хангахаар тусгажээ.


11.Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 473.7 сая төгрөг зарцуулахаар тооцоолсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах болон зам арчилгааны зардалд 164.0 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 107.0 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 106.6 сая төгрөг, хаалт, мониторингийн зардалд 96.1 сая төгрөг, тус тус зарцуулахаар төсөлд тусгажээ.

12.Уг төслийг хэрэгжүүлснээр 22 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 1,159.1 мян.төг байхаар тооцжээ.

13. Элст гол ордыг ашиглах ил уурхайн төсөл хэрэгжүүлэхэд нийт 1.76 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс ил уурхайн хөрөнгө оруулалт 448.22 сая төгрөг, ангилах хэсгийн хөрөнгө оруулалт 115.5 сая төгрөг, захиргаа, аж ахуйн хэсгийн хөрөнгө оруулалт 388.21 сая төгрөг, дэд бүтцийн хөрөнгө оруулалт 375.0 сая төгрөг, эргэлтийн хөрөнгөнд 50.0 сая төгрөг зэрэг хөрөнгө оруулалтын зардлууд тусгажээ.

14. Уурхайг ашиглах төслийн хугацаанд нийт 10,343.8 сая төгрөгийн борлуулалтын орлого олж 7,920.25 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 2,423.56 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 2,181.2 сая төгрөгийн цэвэр ашигтай, 3,448.53 сая төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгалтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 2,166.3 сая төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ.

15.Төсөл хэрэгжих хугацаанд жилийн 10 хувийн хорогдуулалтын норм тооцсон төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV,@10%) 433.69 сая төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 17.7%, хөрөнгө оруулалтаа 3.88 жилд нөхөж байгаа нь төсөл ашигтай хэрэгжих боломжтойг харуулж байна.



Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник-эдийн засгийн үндэслэлийн захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна.

1. Төсөл захиалагчид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 тоот тушаалаар батлагдсан Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн, уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийхийг үүрэг болгож байна
2. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол Улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулж байна.
3. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг ЭБМЗ-өөс даалгаж байна.
4. Засгийн газрын 379-р тогтоолоор батлагдсан “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид анхааруулж байна.
5. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн “Роял Рэнж” ХХК, мөн ТЭЗҮ-ийн үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Монгол Улсын зөвлөх инженер Г.Рэнцэндорж тус тус хариуцна.



Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших MV-017556 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Элст гол"-ын элсний ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хүлээн авах;
2. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байхыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;
3. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших MV-017556 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Элст гол"-ын элсний ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотгол, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЦОГТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Э.МӨНХЗОРИГ



ЭБМЗ-ийн

Т/А - 09/05

дугаар дүгнэлтийн хавсралт

Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших "БММЖ"ХХК -ын МУ-017556 тоол ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй

"Элст гол"-ын элсний ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцооны нэгдсэн хүснэгт

Хүснэгт №1

ЭБМЗ-еер бүртгэгдсэн нөөц							Олборлосон нөөцийн хэмжээ		
Д/д	Нөөцийн блок	Блокийн талбай, м ²	Ашигт малтмалын дундаж зузаан, м	Хуулах хөрсний дундаж зузаан, м	Ашигт малтмалын хэмжээ, м ³	Хуулах хөрсний хэмжээ, м ³	Ашигт малтмалын хэмжээ, м ³	Хуулах хөрсний хэмжээ, м ³	Хуулах хөрсний хэмжээ, м ³
1	B-I	59,372.3	4.21	0.61	249,957.4	36,217.1	-	-	-
2	B-II	60,123.6	4.24	0.59	254,924.1	35,472.9	-	-	-
3	B-III	60,787.2	4.23	0.60	257,129.9	36,472.3	77,500.0	10,992.9	10,992.9
Нийт B нөөц		180,283.1	4.23	0.60	762,011.3	108,162.3	77,500.0	10,992.9	10,992.9

2021.01.01 байдлаарх үлдэгдэл нөөц (ашиглалтын нөөц)		Хаягдлын хэмжээ			Бохирдлын хэмжээ			Үйлдвэрлэлийн нөөц			
Ашигт малтмалын хэмжээ, м ³	Хуулах хөрсний хэмжээ, м ³	Хаягдлын хувь, %	Хаягдлын хэмжээ, м ³	Бохирдлын хувь, %	Бохирдлын хэмжээ, м ³	Нөөцийн блок	Ашигт малтмалын хэмжээ, м ³	Хуулах хөрсний хэмжээ, м ³	Ашигт малтмалын хэмжээ, м ³	Хуулах хөрсний хэмжээ, м ³	Кхх, м ³ /м ³
249,957.4	36,217.1	1.8	4,607.21	2.8	6,910.8	B'-I	252,261.0	40,824.3	40,824.3	0.2	
254,924.1	35,472.9	1.8	4,698.76	2.8	7,048.1	B'-II	257,273.4	40,171.7	40,171.7	0.2	
179,629.9	25,479.4	1.8	3,310.94	2.8	4,966.4	B'-III	181,285.3	28,790.3	28,790.3	0.2	
684,511.3	97,169.4	1.8	12,616.91	2.8	18,925.37	Нийт B'	690,819.8	109,786.4	109,786.4	0.2	

Тооцоо хийсэн: Ашиглалтын инженер

3. Амарбаясгалан





АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 1/114

Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн Т/21-09-05 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших БММЖ ХХК-ийн MV-017556 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Элст гол”-ын нэртэй элсний ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хүлээн авсанд тооцсугай.

2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, геологийн нөөцөөс хөдөлгөөн хийхийг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

3. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллах, техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт тус байгууллагын архивд хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан төслийн хүчин чадал, техник, технологид өөрчлөлт орсон, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

5. Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших БММЖ ХХК-ийн MV-017556 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Элст гол”-ын нэртэй элсний ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн тодотголыг, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд, Уул уурхай, судалгааны хэлтэст тус тус хүлээлгэн өгөхийг БММЖ ХХК-д даалгасугай.

ДАРГА

Х.ХЭРЛЭН



53710839

Журмын 4 дүгээр хавсралт.
Тухайн жилийн байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх,
хүлээж авах загвар

А. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хуудас

6. Уул уурхайн олборлолт, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хуудас

1. Төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн нэр: "БММЖ" ХХК
2. Төслийн байршил: Налайх дүүрэг 5 дугаар хороо
3. Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-017556
4. Огноо: 2023.12.08

#	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүд	Авсан байвал зохих оноо	Ажлын хэсгийн гишүүдийн үнэлсэн оноо							Гийшүүдийн үнэлсэн онооны энгийн арифметик дундаж	Үндэслэл, тайлбар	
			Гишүүн 1	Гишүүн 2	Гишүүн 3	Гишүүн 4	Гишүүн 5	Гишүүн 6	Гишүүн 7			
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	20	20	20	20	20	20	18	20	9	10	11
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт /техникийн нөхөн сэргээлт, биологийн нөхөн сэргээлт, татан буулгах, хаалтад бэлтгэх/	30	—	—	15	30	28	30				
3	Биологийн олон янз байдлыг дийдүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	10	20	10	10	10	10	10	10			

4	Нүүлэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт	5	-	-	-	-	-	-	-	5			
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний биелэлт	5	-	-	-	-	-	-	-	5			
6	Осол, эрдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	10	10	10	10	10	10	10	10	10			
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5			
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	5	5	5	5	5	5	5	5	5			
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	5	-	-	8	5	5	5	5	5			
10	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт	5	-	-	5	5	5	5	5	5			
	Нийт оноо	100	90%	90%	88%	90%	94%	90%	94%	100%			

Тайлбар: Бүрэлдэхүүн хэсэг тус бүрт биелэлтээ нь хамааран авсан байвал зохих оноог тогтоосон ба ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн онооны энгийн арифметик дунджийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тооцож гаргана. Гишүүдийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрт өгсөн онооны энгийн арифметик дунджийн нийлбэр нь нийт оноо болно. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн биелэлтийн нийт оноо нь 90-аас доош байвал төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй гэж үзнэ. Тухайн жилд дүйцүүлэн хамгаалах ажил төлөвлөгөөгүй бол нөхөн сэргээх арга хэмжээ рүү, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ төлөвлөгөөгүй бол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт рүү шилжүүлж тооцно.

Ажлын хэсгийн ахлагч: _____ /Ч.Мөнхбаяр/ (Гишүүн 1) /99112389/



Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: _____

[Signature] /Ж.Батзолбоо/

Гийшүүд:
Нийслэлийн Байгаль орчны газрын Хяналтын хэлтсийн
Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч _____

/Д.Батзориг/

Туул голын сав газрын захиргааны
Усны нөөц, ус ашиглалтыг зохицуулах албаны
Дарга _____

/П.Энхбаяр/

Тухайн нутаг дэвсгэрийг харуулсан байгаль хамгаалагч _____

/Э.Бат-Эрлэнэ/

Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэдийн төлөөлөл _____

/Т.Саломс /

Хүлээн зөвшөөрсөн:
“БММЖ” ХХК –ийн Гүйцэтгэх Захирал _____

[Signature] /Л.Дампийхүү/ 94119209,



ОЙ, УС, ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗРЫН
КАДАСТРЫН ЛАВЛАГААНЫ МЭДЭЭЛЛИЙН САН

Кадастрын лавлагаа

Лавлагааны мэдээлэл



Таны лавлагаа авах хүсэлт мэдээллийн санд бүртгэгдлээ. Хүсэлтийг хянан Ашиг малтмал, газрын тосны газарт цахим байдлаар хүргэгдэнэ.

Тусгай зөвшөөрлийн дугаар	MV-017556
Талбайн нэр	Элст гол
Тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээ, га	19.29
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	БММЖ
Аймаг, сум, сав газрын нэр	Улаанбаатар хот Налайх дүүрэг, Туул голын сав газар
Хуулиар хориглосон бүстэй давхцалтай эсэх	давхцалгүй
Давхацсан талаарх мэдээлэл	



ТАНИХ ТЭМДЭГ





Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

-  Ашиглалтын
-  Хайгуулын



Засаг захиргааны хил

-  Улсын хил
-  Аймгийн хил
-  Сумын хил
-  Аймгийн төв
-  Сумын төв



Тусгай хамгаалалттай газар нутаг

-  Дархан цаазат газар
-  Байгалийн цогцолборт газар
-  Байгалийн нөөц газар
-  Дурсгалт газар




Хамгаалалтын бүсүүд

-  Гол мөрний урсац бүрэлдэх эх
-  Ойн сан бүхий газар


Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс

-  Онцгой хамгаалалтын бүс
-  Энгийн хамгаалалтын бүс

Ус хангамжийн эх үүсвэр

-  Эрүүл ахуйн хориглолтын бүс
-  Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс
-  Тэжээгдлийн муж

Орон нутгийн усны хамгаалалтын бүс

-  Орон нутгийн усны хамгаалалтын бүс

Масштаб 1:5565.0

0 100 200 300 400 м



Маягт БОХ-3**УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН УЛМААС ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН
СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАН
/ 2024 ОН /****А.Хаягийн хэсэг**

Байгууллагын нэр	“БММЖ” ХХК
Регистрийн дугаар	5097428
Нийслэл /хот/ аймаг	Улаанбаатар
Сум/дүүрэг	Налайх
Газрын нэр	Элст гол
Тусгай зөвшөөрлийн дугаар	МУ-017556
Тусгай зөвшөөрлийн талбай	19,29
Ашигт малтмалын төрөл	элс
Олборлох, баяжуулах технологи	боловсруулах
БОННУ хийсэн байгууллага	“Саблайм” ХХК
БОННУ хийсэн он	2022 он
Хаяг	УБ, БГД, 10-р хороо, Зүүн наран 3, 05 тоот
Утас	976-88882778
Мэйл хаяг	

А.Уул уурхайн нөхөн сэргээлт

Үзүүлэлт	Мөрийн дугаар	Хэмжих нэгж			
А	Б	В			
1.Олборлолт эхэлсэн он	1		2021		
2.Олборлолтонд өртсөн талбай					
Олборлолт эхэлсэн үеэс өссөн дүнгээр	Олборлолтонд өртсөн газар	Гүн	2	м	4.5
		Талбай	3	га	9.1
		Эзлэхүүн	4	мян.м ³	472.52
	Гадаад овоолго /Дотоод овоолго/	Өндөр	5	м	3 м хүртэл
		Талбай	6	га	
		Эзлэхүүн	7	мян.м ³	32.5
	Бусад	Гүн	8	м	
		Талбай	9	га	
		Эзлэхүүн	10	мян.м ³	
	Олборлолт явуулсан тайлант онд	Олборлолтонд өртсөн газар	Гүн	11	м
Талбай			12	га	2.1
Эзлэхүүн			13	мян.м ³	90
Гадаад овоолго		Өндөр	14	м	3 м хүртэл
		Талбай	15	га	
		Эзлэхүүн	16	мян.м ³	17.2
Бусад		Гүн	17	м	
		Талбай	18	га	

		Эзлэхүүн	19	мян.м ³	
Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Олборлолтонд өртөх газар	Гүн	20	м	4.5
		Талбай	21	га	2.1
		Эзлэхүүн	22	мян.м ³	90
	Гадаад овоолго	Өндөр	23	м	3 м хүртэл
		Талбай	24	га	
		Эзлэхүүн	25	мян.м ³	10.15
	Бусад	Гүн	26	м	
		Талбай	27	га	
		Эзлэхүүн	28	мян.м ³	

3. Техникийн нөхөн сэргээлт

Олборлолт эхэлсэн үеэс өссөн дүнгээр	Техникийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	29	га	4.3
		Эзлэхүүн	30	мян.м ³	
	Гадаад овоолго	Талбай	31	га	1.6
		Эзлэхүүн	32	мян.м ³	
	Бусад	Талбай	33	га	
		Эзлэхүүн	34	мян.м ³	
Олборлолт явуулсан тайлант онд	Техникийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	35	га	1.6
		Эзлэхүүн	36	мян.м ³	
	Гадаад овоолго	Талбай	37	га	1.6
		Эзлэхүүн	38	мян.м ³	
	Бусад	Талбай	39	га	
		Эзлэхүүн	40	мян.м ³	
Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Техникийн нөхөн сэргээлт хийсэн газар	Талбай	41	га	1.6
		Эзлэхүүн	42	мян.м ³	
	Гадаад овоолго	Талбай	43	га	
		Эзлэхүүн	44	мян.м ³	
	Бусад	Талбай	45		
		Эзлэхүүн	46	мян.м ³	

4. Биологийн нөхөн сэргээлт

Олборлолт эхэлсэн үеэс өссөн дүнгээр	Биологийн нөхөн сэргээлт хийсэн газар	талбай	47	га	1.92
	Гадаад овоолго	талбай	48	га	
	Бусад	талбай	49	га	
Олборлолт явуулсан тайлант онд	Биологийн нөхөн сэргээлт хийсэн газар	талбай	50	га	0.9
	Гадаад овоолго	талбай	51	га	
	Бусад	талбай	52	га	

Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Биологийн нөхөн сэргээлт хийсэн газар	талбай	53	га	0.9
	Гадаад овоолго	талбай	54	га	
	Бусад	талбай	55	га	
б.Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгө	Олборлолт эхэлсэн үеэс өссөн дүнгээр		56	сая.төг	11.77
	Олборлолт явуулсан тайлант онд		57	сая.төг	3.75
	Олборлолт явуулах төлөвлөгөөт онд		58	сая.төг	3.75
б.Байгаль орчныг хамгаалахад зарцуулсан хөрөнгө	Олборлолт эхэлсэн үеэс өссөн дүнгээр		59	сая.төг	23.07
	Олборлолт явуулсан тайлант онд		60	сая.төг	7.02
	Олборлолт явуулах төлөвлөгөөт онд		61	сая.төг	6.55
7. Олборлолт явуулах төлөвлөгөөт онд	Хөрс хуулалт	талбай	62	га	
		хэмжээ	63	мян.м ³	10.15
	Хүдэр олборлолт	талбай	64	га	2.1
		хэмжээ	65	мян.м ³	90.00
	Бүтээгдэхүүн гаргалт		66	мян.тн	
		67	кг	-	
8.Олборлолтод ашиглагдах ус	Усны төрөл		68		Гүн (шүүрэл)
	Усны хэмжээ		69	мян.м ³	5.76
9.Химийн хорт аюултай бодисын зарцуулалт	Зөвшөөрөгдсөн хэмжээ		70	кг	байхгүй
	Зарцуулсан хэмжээ		71	кг	
10.Олборлолтод өртсөн ойн бүрхэвч	Талбайн хэмжээ		72	га	байхгүй
	Нөөцийн тоо хэмжээ		73	м ³	

“БОХ-3” тайланг үнэн зөв гаргасан:

“БММЖ” ХХК-ийн БО-ны мэргэжилтэн



/ Ц. Хулан/

БАТЛАВ: БММЖ ХХК-ийн
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Л.ДАШИЙХҮҮ /

ЗӨВШӨӨРСӨН: НБОГ-ЫН ДАРГА:
Р.ЭНХТАЙВАН /



**УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГТ
ОРШИХ “ЭЛСТ ГОЛ”-ийн УУРХАЙН 2024 ОНЫ АШИГЛАЛТЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

(ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-017556)

ХЯНАСАН:

НБОГ-ын ахлах мэргэжилтэн: / Д. БАТЗОЛБОО /

БОЛОВСРУУЛСАН:

Ерөнхий инженер: / Ц.ХУЛАН /

2023 он

Маягт № 10
Тусгай зөвшөөрлийн дугаар: МВ-17556
Ашигт малтмалын төрөл: Берлм (Элс)
Он: 2024

"ЭЛСТ ГОЛ" ИЛ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТ, СУРАЛЛАЛ

№	Үзүүлэлт	Талбай		Зээлхүүн		Нөхөн сэргээлтэд зарцуулах зардлын хэмжээ		Тайлбар	Байр зүйн хэмжээгдэхүүн	Талбайн буталгын цаг			Тэгш өнцөгт солигчлын систем
		Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга	Хэмжих нэгж	Тоон утга			Град	Мин	Сек	
1	Техникийн нөхөн сэргээлт	га	1.0	мян.м.куб	сая.төг	1.60	Зардалыг ашиглалтын зардалд шингэсэн тосцов.	Уургаг	47	47	56.3	685,222.17	
								Өргөрөг	107	28	24.6	5,298,920.09	
2	Биологийн нөхөн сэргээлт	га	0.9	мян.м.куб	сая.төг	1.60	Уурхайн талбайд 500 ширхэг мод төрөл эсвэл олон наст ургамлын үр цэцэц	Уургаг	47	47	56.42	685,353.47	
								Өргөрөг	107	28	30.92	5,298,927.82	
								Уургаг	47	47	52.77	685,300.54	
								Өргөрөг	107	28	32.67	5,298,816.53	
								Уургаг	47	47	53.78	685,191.64	
								Өргөрөг	107	28	23.01	5,298,841.27	
3	Бусад	га	0.0	мян.м.куб	сая.төг	1.60	Уурхайн талбайд 500 ширхэг мод төрөл эсвэл олон наст ургамлын үр цэцэц	Уургаг	47	47	56.07	685,269.02	
								Өргөрөг	107	28	27.84	5,298,942.75	
								Уургаг	47	47	50.09	685,324.20	
								Өргөрөг	107	28	29.84	5,297,009.82	
								Уургаг	47	47	58.87	685,439.37	
								Өргөрөг	107	28	35.16	5,297,008.34	
4	Нийт	га	2.10	мян.м.куб	сая.төг	1.60	Уулын ажигд хамрагдах	Уургаг	47	47	52.52	685,163.01	
								Өргөрөг	107	28	21.57	5,296,801.29	
								Уургаг	47	47	52.5	685,465.10	
								Өргөрөг	107	28	36.1	5,298,810.49	
								Уургаг	47	47	50.5	685,453.66	
								Өргөрөг	107	28	35.45	5,296,748.25	
5	Бусад	га	2.10	мян.м.куб	сая.төг	1.60	Зардалыг ашиглалтын зардалд шингэсэн тосцов.	Уургаг	47	47	50.19	685,186.28	
								Өргөрөг	107	28	21.62	5,296,729.45	
								Уургаг	47	47	52.52	685,163.01	
								Өргөрөг	107	28	21.57	5,296,801.29	
								Уургаг	47	47	52.5	685,465.10	
								Өргөрөг	107	28	36.1	5,298,810.49	
6	Бусад	га	2.10	мян.м.куб	сая.төг	1.60	Зардалыг ашиглалтын зардалд шингэсэн тосцов.	Уургаг	47	47	50.5	685,453.66	
								Өргөрөг	107	28	35.45	5,296,748.25	
								Уургаг	47	47	50.19	685,186.28	
								Өргөрөг	107	28	21.62	5,296,729.45	
								Уургаг	47	47	52.52	685,163.01	
								Өргөрөг	107	28	21.57	5,296,801.29	
7	Бусад	га	2.10	мян.м.куб	сая.төг	1.60	Зардалыг ашиглалтын зардалд шингэсэн тосцов.	Уургаг	47	47	52.5	685,465.10	
								Өргөрөг	107	28	36.1	5,298,810.49	
								Уургаг	47	47	50.5	685,453.66	
								Өргөрөг	107	28	35.45	5,296,748.25	
								Уургаг	47	47	50.19	685,186.28	
								Өргөрөг	107	28	21.62	5,296,729.45	
8	Бусад	га	2.10	мян.м.куб	сая.төг	1.60	Зардалыг ашиглалтын зардалд шингэсэн тосцов.	Уургаг	47	47	56.74	685,437.20	
								Өргөрөг	107	28	34.50	5,298,940.57	
								Уургаг	47	47	52.52	685,163.01	
								Өргөрөг	107	28	21.57	5,296,801.29	
								Уургаг	47	47	52.5	685,465.10	
								Өргөрөг	107	28	36.1	5,298,810.49	
9	Бусад	га	2.10	мян.м.куб	сая.төг	1.60	Зардалыг ашиглалтын зардалд шингэсэн тосцов.	Уургаг	47	47	50.5	685,453.66	
								Өргөрөг	107	28	35.45	5,296,748.25	
								Уургаг	47	47	50.19	685,186.28	
								Өргөрөг	107	28	21.62	5,296,729.45	
								Уургаг	47	47	52.52	685,163.01	
								Өргөрөг	107	28	21.57	5,296,801.29	
10	Бусад	га	2.10	мян.м.куб	сая.төг	1.60	Зардалыг ашиглалтын зардалд шингэсэн тосцов.	Уургаг	47	47	52.5	685,465.10	
								Өргөрөг	107	28	36.1	5,298,810.49	
								Уургаг	47	47	50.5	685,453.66	
								Өргөрөг	107	28	35.45	5,296,748.25	
								Уургаг	47	47	50.19	685,186.28	
								Өргөрөг	107	28	21.62	5,296,729.45	

Үзүүлэлт гаргасан: 
Төлөөлгөө харуулсан мэргэжилтэн: Ц. Дорнод, Д. Хулан

Хүлээн авсан: 
НӨӨГ, ХӨӨБНХ мэргэжилтэн: 


Маягт № 11
 Тусгай зөвшөөрлийн дугаар: МВ-17556
 Ашигт малтмалын төрөл: Бар/м (Элс)
 Он: 2024

"ЭЛСТ ГОЛ" ИЛ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ НӨЛӨӨЛЛИЙГ ҮНЭЛЭХ, ХАМГААЛАХ

№	Үзүүлэлтүүд	Уурхайн нөлөөлөлд өртөх талбайн хамрах хүрээ		Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	
		Хэмжих нэгж	Тоон утга	Хийгдэх ажил текст	Хэмжих нэгж Тоон утга
1	Хөрс		15.6	Хөрсний хяналтын цэгүүдээс дээж авч шинжлүүлнэ	80.00
2	Ус		8.6	Шүүрлийн уснаас дээж авч шинжлүүлэн стандарттай харьцуулна.	60.00
3	Агаар		8.6	Тоосжилтыг усалж дарах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ. Агаарын чанарын дээж авч шинжлүүлж, стандарттай харьцуулна.	60.00
4	Ургамал / Амьтан	км.квад		Шимт хөрсийг 0.04 м-ийн зузаантайгаар хуулан овоолно.	10.00
5	Түүх соёлын дурсгалт газар		0	Нөлөөгүй	-
6	Оршин суугчид		0	Нөлөөгүй	-
7	Уурхайн байгаль орчны удирдлага зохион байгуулалт			Тайлан, төлөвлөгөөг хуулийн хугацаанд тайлагнах, бусад холбогдох ажлууд	
8	Бусад			Орон нутагтай хамтран ажиллах гэрээний дагуу хийгдэх ажил	

Үзүүлэлт гаргасан: *[Signature]*
 Төлөвлөгөө хариуцсан мэргэжилтэн: *[Signature]* Ц.Хулан
 НБОГ, ХБОБНХ мэргэжилтэн *[Signature]*

Шинж
 2.1 сая. 700.



Таних тэмдэг

	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн хил		Нөөцийн блок, түүний дугаар		Ил уурхай
	Хайлбар түүний өндөржилт		Нөөцийн блокийн хүрээ		Дотоод овоолго
	Хайгуулын малтлт, түүний дугаар		Хайгуулын шугам, түүний дугаар		

малталтын гүн, м
хөрсний зузаан, м
элсний зузаан, м

"БММЖ" ХХК				УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДУРГУЙН НУТАГТ ОРШИХ "ЭЛСТ ГОЛЫН" ЭЛСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ 2023 ОНЫ АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ (Жилийн хүчин чадвал 90.0 мян.м ³)		
Үүрэг	Овог нэр	Г.усгаг	С/ед	Масштаб	Хууд.тоо	Он.сар
Захирал	Л.Дашийхүү			1: 1000	1	2022.12
Гүйцэтгэсэн	Ц.Хулан			Зураг № 1		
ДЭВСГЭР ЗУРАГ				"БММЖ" ХХК		

3,275,000.00

Он сар өдөр 2024 3 29	Дүн / Amount Мөнгөний нэгж / Currency <input checked="" type="checkbox"/> MNT <input type="checkbox"/> USD <input type="checkbox"/> Бусад	(ГЭВЭН ДАЯ ХӨӨР) ЗУУН ДАЛАН ТАВАН МЯНГАН ТӨГРӨГ	
ХЭНЭЭС / FROM IBAN: MN03001500	Дансны нэр / Account name БММЖ	Төлбөрийн зориулалт / Details of payment 2024 ОНЫ БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА БММЖ ХХК 2024 ОНЫ БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА СОЛБЭЭХ БАТАЛГАА БММНН ХХК	
	Дансны дугаар / Account No. 1 2 0 5 2 2 3 2 8 8		
ХЭНД / TO IBAN:	Банкны нэр / Bank name ТӨРИЙН САН	Гарын үсэг / Signature	Тамга / Stamp
	Дансны нэр / Account name БО НӨХӨН СЭРГЭЭХ БАТАЛГАА	1st M. Lamiid	
	Дансны дугаар / Account No. 1 0 0 9 0 0 0 1 3 4 0 6	2nd	

ЗӨВХӨН БАНКНЫ ХЭРЭГЦЭЭНД / FOR BANK USE ONLY		ТЭМДЭГЛЭЛ / NOTE:	
ХҮА / TELLER:		Шилжүүлэх данс	1205223288
Хянасан / Verified by:		Хүлээн авах данс	100900013406
Он / сар / өдөр	/ YYYY / MM / DD	Хүлээн авах дансны нэр	БО НӨХӨН СЭРГЭЭХ
	29 МАК 2024	Хүлээн авагчийн банк	ТӨРИЙН САН
		Мөнгөн дүн	3,275,000

БАТЛАВ:
ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА

Г. ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:
"БММЖ" ХХК ЗАХИРАЛ

Л. ДАШИЙХҮҮ

"БММЖ" ХХК НИЙ УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГ
ДЭВСГЭРТ ХЭРЭГЖИНЭ."ЭЛСТ ГОЛ" НЭРТЭЙ ЭЛСНИЙ ОРДЫГ ИЛ
АРГААР АШИГЛАХ ТӨСӨЛ ТӨСЛИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ
ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-017556
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5097428



ХЯНАСАН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

БАЯРТАЙВАН. СОЛОНГО

БОЛОВСРУУЛСАН:
"БММЖ" ХХК БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭРГЭЖИЛТЭН

Ц. ХУЛАН

2024 ОН

БАТЛАВ :
БОАЖЯ –НЫ ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Г.ЭНХМӨНХ

ШҮҮМЖ ХИЙСЭН:
БОАЖЯ -НЫ ШИНЖЭЭЧ

О.АМАРСАНАА

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН НУТАГТ
БАЙРЛАХ “ЭЛСТ ГОЛ”-ЫН ЭЛСНИЙ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН НЭМЭЛТ ТОДОТГОЛ

Төсөл хэрэгжүүлэгч : “БММЖ” ХХК

Нарийвчилсан үнэлгээ хийсэн :
“САБЛАЙМ” ХХК -ийн
Гүйцэтгэх захирал



Д.МӨНХЖИН

Төсөл хэрэгжүүлэгч :
“БММЖ” ХХК -ийн
Захирал — а



Г.МӨНХБОЛД

**МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 5/2, Засгийн газрын II байр,
Утас: 26 19 66, Факс: (976-51) 26 61 71,
И-мэйл: contact@mne.gov.mn, Вэбсайт: www.mne.mn

2021.10.15 № 13/4868

танай _____-ныг № _____-т

**Ерөнхий үнэлгээний дүгнэлт
хүргүүлэх тухай**

Танай компаниас ирүүлсэн Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт Элст гол нэртэй газарт орших “Элсний ордыг ашиглах төсөл”-д “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журам”-ын 3 дахь хэсгийг үндэслэн, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ.

Ерөнхий үнэлгээний дүнгээр уг төсөлд аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ /нэмэлт тодотгол/ хийлгэх шаардлагатай гэж үзэв.

Төсөл хэрэгжүүлэгч нь Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, 2022 оны 2 дугаар улиралд багтаан тус яаманд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

Хавсралт 4... хуудастай.

ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Г.ЭНХМӨНХ

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУУДАС

2021 оны 10-р сарын 15

Улаанбаатар хот

Төслийн дугаар

Дугаар 2021/J097

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг: “БММЖ” ХХК, регистрийн дугаар-5097428, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 19-22 тоот.

Төслийн нэр: Элс-хайрганы хольцын ордыг ашиглах.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил: Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт Элст гол нэртэй газарт орших ашигт малтмалын ашиглалтын MV-017556 дугаартай тусгай зөвшөөрөл бүхий талбайд хэрэгжинэ. Ордыг ашиглах ТЭЗҮ /тодотгол/-ийг АМГТГ-ын даргын 2021 оны 07-р сарын 06-ний өдрийн Т/117 дугаар тушаалаар хүлээн авсан байна.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ: Төсөл хэрэгжих газрын Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг “Саблайм” ХХК гүйцэтгэсэн байна.

Холбоо барих утас: +976-8888-2778.

Орон нутгийн санал: Төсөл хэрэгжих Улаанбаатар хотын Налайх дүүргийн Засаг даргын 2021 оны 06-р сарын 11-ний өдрийн 04/771 дугаартайт албан бичгээр ирүүлсэн санал болон төсөл хэрэгжүүлэгчийн 2021 оны 07-р сарын 22-ны өдрийн /E-Mongolia/ 099-2107-000123 дугаартай цахимаар ирүүлсэн Ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /нэмэлт материал/ зэргийг харгалзан үзэв.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурууд		Нийцсэн		Нийцээгүй	
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт			Тийм	Нарийвчилсан үнэлгээний явцад хууль тогтоомжийн нийцлийг нарийвчлан тодорхойлох
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт	Тийм			
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэхүүн, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилын хамгаалалтын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтэй эсэх			Тийм	
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжлөд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг			Тийм	

	нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх				
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх			Тийм	
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх			Тийм	
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх			Тийм	
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх			Тийм	
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эгнэх			Тийм	
	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх			Тийм	
	Хөрсөн бүрхэвч				
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх			Тийм	
	Хөрс бохирдуулах эсэх			Тийм	
	Хөрс доройтох, цөлжих эсэх			Тийм	
	Ургамлан нөмрөг				
	Ургамалан нөмрөг, ой мод өртөх эсэх			Тийм	
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх			Тийм	
Амьтны аймаг					
Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх			Тийм		
Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх			Тийм		
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид				
	Газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх			Тийм	
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх			Тийм	
	Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх			Тийм	
	Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх			Тийм	
	Түүх, соёлын биет өв				
	Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх			Тийм	
	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл				
Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх			Тийм		
Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх			Тийм		
Нэгдсэн дүгнэлт:					
<p>Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт Элст гол нэртэй газарт орших “Элсний ордыг ашиглах төсөл”-д хийсэн Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлээр уг төсөлд батлагдсан аргачлалын дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ /нэмэлт тодотгол/ хийлгэх шаардлагатай гэж үзлээ.</p>					

Онцгойлон анхаарах зүйлс:

1. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг шинэчлэн батлагдсан Техник эдийн засгийн үндэслэлд тулгуурлан хийлгэх бөгөөд олборлолт, боловсруулалтын технологийн дарааллыг нарийвчлан тодорхойлж, технологийн сонголтод үнэлэлт дүгнэлт өгөх;
2. Төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчин /агаар, ус, хөрс, амьтан, ургамал г.м/-д үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүний хамрах хүрээ, учруулах хорхирлын хэмжээг тооцож, нийлбэр үнэлгээг гарган уг төслийг экологи, эдийн засгийн үр ашигтайгаар хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар шинэчлэн дүгнэлт гаргах;
3. Тухайн орд газрын гадаргын болон газрын доорх усны харилцан хамаарал, уст үеийн хөдөлгөөн, тархалтыг олборлох технологитой уялдуулан дахин судалж, эрх бүхий байгууллагаар усны нөөцийн дүгнэлт гаргуулах;
4. Элс-хайрганы хольц олборлох болон төслийн бүрэлдэхүүн хэсгээс ялгарах бохирдлын хэмжээ, түүний тархалт, нөлөөллийг хүрээг шинээр тодорхойлж, зураглал үйлдэн тайланд хавсаргах;
5. Төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлд өртөх талбайн хэмжээг нарийвчлан тооцож, үлдэгдэл нөлөөллийг Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тухай бүс нутагт байрлах эврэлд орж, эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх замаар биологийн олон янз байдлын амьдрах орчныг бүрдүүлэх саналыг боловсруулж, шаардагдах зардлыг тайланд тусгах;
6. Бүтээгдэхүүн тээвэрлэх авто замыг Засгийн газрын 2018 оны 379 дүгээр тогтоолоор батлагдсан “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын шаардлагад нийцүүлэх асуудлыг тайланд нарийвчлан тусгах;
7. УУХҮ-ын болон БОАЖ-ын Саидын 2019 оны 8-р сарын 28-ны өдрийн А/181, А/458 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ын дагуу уурхайн хаалтын урьдчилсан төлөвлөлтийг хийж, тайланд тусгах;
8. Үйл ажиллагааны явцад баримтлах хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажиллагсдын эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн бууруулах зөвлөмж, дүгнэлт боловсруулах;
9. “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 10¹-р зүйлд заасны дагуу төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг төслийн 2 дахь жилээс хийлгэх, аудитын дүгнэлт зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлэх хугацаа, зардлыг тайланд тусгах;
10. БОННУ-д үндэслэн боловсруулсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр/-г боловсруулж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлыг эхний 5 жилээр тооцож ирүүлэх;
11. Эцэслэн боловсруулсан БОННУ-ний ажлын тайланг төсөл хэрэгжих багийн ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын тэмдэглэл, шийдвэрийг тайланд хавсаргах.

Бусад зүйлс:

1. Төслийн үйл ажиллагаатай холбогдуулж орон нутгийн засаг захиргааны болон байгаль орчны хяналтын байгууллагаас тавигдах нэмэлт шаардлагыг тухай бүрт нь ханган биелүүлж байх;

2. Нарийвчилсан үнэлгээний тайланд шүүмж хийлгэн дүгнэлт, шийдвэр гаргуулах асуудлыг ерөнхий үнэлгээгээр тогтоосон хугацаанд хэрэгжүүлэх;
3. Төслийн хүчин чадал, техник, технологит өөрчлөлт орсон тохиолдолд ерөнхий үнэлгээнд тухай бүрт хамргадаж, шийдвэр гаргуулж ажиллах шаардлагатай болно.

Заавал хэрэгжүүлэх шаардлагатай дээр дурьдсан арга хэмжээг цаг хугацаанд ханган биелүүлээгүй тохиолдолд ерөнхий үнэлгээний дүгнэлтийг хүчингүй болгож, “Зөрчлийн тухай” хуулийн 7.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу хариуцлага тооцдог болохыг анхаарна уу.

Ерөнхий үнэлгээ хийсэн:
**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ЯАМНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ШИНЖЭЭЧ**

Гарын үсэг:



111 Д.ШИЖИР-ЭРДЭНЭ

Ерөнхий үнэлгээний үр дүнг
зөвшөөрсөн:
“БММЖ” ХХК -ийн захирал

Гарын үсэг:



А.Даушияуу

Г.Мөнхболд

“БММЖ” ХХК

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 10-р
хороо, Зүүн наран 3, 05 тоот
Утас:976-94119209

**НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ГАЗАРТ**

2024. 01. 31 № 03/24

танай _____-ны № _____-г

Хүсэлт гаргах нь

Манай компани нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 5-р хорооны нутагт орших MV-017556 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий “Элст гол” нэртэй талбайг эзэмшдэг.

2023/01 дугаартай “Ус ашиглах гэрээ”-г дүгнэн, 2024 онд сунгуулах хүсэлтэй байгаа тул хүлээн авна уу.

ЗАХИРАЛ



/Л. ДАШИЙХҮҮ/



УС АШИГЛАХ ЭРХИЙН БИЧИГ

Дугаар

Түүш *лагын* *сав* *нурин* *далуулаа*-ын
/Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба/
гаргасан 20*23* оны *04*-р сарын *17*-ны өдрийн *23/01* дугаартай ус ашиглуулах дүгнэлт,
Нийслэлийн Байгаль орчног газар-ын
/Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга/
олгосон 20*23* оны *04*-р сарын *07*-ны өдрийн ус ашиглах зөвшөөрөл, *А/39*
Нийслэлийн Байгаль орчног газар-тай
/Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Засаг дарга, ус хангаач байгууллага/
20*23* оны *04*-р сарын *10*-ны өдөр байгуулсан *2023/01* дугаар бүхий ус
ашиглах гэрээг үндэслэн *Нийслэлийн* аймаг, нийслэл,
Сүдбаатар сум, дүүрэг *3* баг, хорооны
/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хаяг/
нутагт байршилтай, улсын бүртгэлийн *9011034017* тоот гэрчилгээтэй,
5097428 регистрийн дугаартай *"БММЖ" ХХК* -г
/Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр/
ус ашиглахад тавигдах шаардлагыг бүрэн хангасан гэж үзэж, *СӨД, 3р хороо*
байршилтай усны нөөцөөс хоногт *72.9* шоо метр усыг
/гвдаргын ус, газрын доорхи ус/
уш *уургаийн* зориулалтаар ашиглах ЭРХИЙН БИЧИГ-ийг гурван
жилийн хугацаагаар олгов.

Эрхийн бичиг олгосон:

НБОН-ын дарга Р.Аюуш Р.Мэтайван
аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, сум, дүүргийн Байгаль хамгаалагч

/байгууллага, албан тушаалтны нэр, газрын үсэг/



20*23* оны *04*-р сарын *10*-ны өдөр

ГЭРЭЭ ДҮГНЭСЭН ПРОТОКОЛ

2024.01.10

Гэрээний нэр:	Ус ашиглах гэрээ
Гэрээний дугаар:	2023/01
Ус ашиглуулагч байгууллага:	Нийслэлийн Байгаль Орчны Газар
Ус ашиглагч байгууллага:	БММЖ ХХК
Гэрээ эхлэх хугацаа:	2023.01.01
Гэрээ дуусах хугацаа:	2023.12.31
Ус ашиглах дүгнэлт:	Туул голын сав газрын захиргааны 2023.01.17-ны өдрийн 23/01 дугаартай ус ашиглуулах дүгнэлтээр 7776 м ³ ус ашиглах урьдчилсан тооцоо гарсан.
Ус ашиглах гэрээ:	Туул голын сав газрын дүгнэлтээр 815 617 төгрөгийг Налайх дүүргийн Татварын хэлтэст төлнө.
Ашигласан усны хэмжээ:	2023.12.31 байдлаар 7776 м ³
Ус ашигласны төлбөрийн хэмжээ:	2023.12.31 байдлаар 815 617 төгрөг


Гэрээний биелэлт, шийдвэрлэлт:

Гэрээний биелэлт:	Нийслэлийн Байгаль Орчны Газар нь “БММЖ” ХХК-тай 2023/01 дугаартай Ус ашиглах гэрээг байгуулсан. Гэрээнд заасан шаардлагаа биелүүлж ажилласан байна.
Шийдвэрлэлт:	2024 онд Ус ашиглах гэрээ байгуулж ажиллах.

Гэрээг дүгнэсэн:

Захиалагч:

НБОГ-ын дарга

 Р. Энхтайван

НБОГ-ын Ойн хэлтсийн усны асуудал
эрхэлсэн ахлах мэргэжилтэн

 Ч. Дамбасүрэн

Гүйцэтгэгч:

“БММЖ” ХХК-ийн захирал

 Л. Дашийхүү

“БММЖ” ХХК-ийн мэргэжилтэн

 Ц. Хулан

БАТЛАВ.
НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ГАЗРЫН ДАРГА
Р.ЭНХТАЙВАН

БАТЛАВ.
"БММЖ" ХХК-ийн ЗАХИРАЛ
Л.ДАШИЙХҮҮ

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2024 оны 2 сарын 06-ны өдөр

Дугаар 2024/07

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл:

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу Туул голын сав газрын захиргааны 2023 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн 23/01 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Нийслэлийн Байгаль орчин газрын 2023 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн А/39 дугаартай ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн: Ус ашиглуулагчийг төлөөлж **нийслэлийн Байгаль орчны газрын** Ойн хэлтсийн Усны асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Чойндонжамц овогтой Дамбасүрэн, Ус ашиглагчийг төлөөлж нийслэлийн Сүхбаатар дүүргийн 3-р хороо, Сөүлийн гудамж, 19-р байр, 22 тоот, 9011034017 дугаартай улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 5097428 регистрийн дугаартай "БММЖ" ХХК-ийг төлөөлж менежер дарга Цэдэн овогтой Хулан нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2024 оны 1 дүгээр сарын 01-ээс нөхөн тооцож 2024 оны 12 дугаар сарын 31-ныг дуустал 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл:

